



# Инженер техникийн хэсгийн 3 дугаар сарын үйл ажиллагааны тайлан

2023.03.28



# 1. Захиалагчийн хяналт:

Нийтийн зориулалттай орон сууцны барилгын 20 цахилгаан шатны шинэчлэлийн ажил 2022-2023 оны дамжин хэрэгжиж байна.

Үүнээс –

- Фүшили элеватор ХХК 4 лифт /2 лифт нь улсын комисс хүлээж авсан, 2 лифтний тээвэрлэлт хийгдэж байна./
- Төвхөн трейд ХХК 6 лифт /5 лифтний угсралтын ажил хийгдэж байгаа, 1 лифтний захиалга хийгдсэн/
- Оакс экспресс монголиа ХХК 10 лифт /10 лифтний угсралтын ажил хийгдэж байна./

2023 онд шинэчлэгдэх 4 цахилгаан шатны тендер 03 дугаар сарын 29 –ны өдөр нээнэ.



## 2. Засвар, техник үйлчилгээ:

Гэрээт 52 ААНБ, СӨХ-дын 153 лифтэнд засвар, техник үйлчилгээ хийхээс 52 ААНБ, СӨХ-дын 144 лифт, мөн гүүрэн гарцны 8 лифт, нийт 152 лифтэнд засвар, техник үйлчилгээг хийлгэж, механикуудын ажлын гүйцэтгэлд хяналт тавьж бүртгэл хөтөлж ажилласан.

Тус хугацаанд “Кремль” СӨХ 2 лифт шинэчлэгдэж байгаа тул ТҮ хийлгээгүй, “Сансар өргөө” СӨХ-ны 1 лифт нэмж гэрээ байгуулсан.

Гэрээт ААНБ, СӨХ-доос нийт 30 дуудлага ирснийг цаг хугацаанд нь засварлан лифтүүдийг хэвийн ажиллагаанд оруулсан. Мөн тайлант хугацаанд нийт 6 лифтэнд томоохон засварын ажил хийж гүйцэтгэсэн. Үүнд: “Ган зам 50, 50А” СӨХ-ны 50-р байрны 1 лифт, 50А байрын 2 лифт, нийт 3 лифтний бүхээгний гэрлэн мэдрэгч шинээр сольсон, ДБҮЭГ-ын 3 лифтийн зам төмөр дээр гулсах бүхээгний гулсагч /башмак/ шинээр сольж лифтийг хэвийн ажиллагаанд оруулсан.

### 3. Гүүрэн гарц

Нийслэлийн Засаг даргын 2022 оны 10 дугаар сарын 11-ний өдрийн А/1320 тоот эрх шилжүүлэх тухай захирамж, Улаанбаатар хотын ерөнхий менежерийн 2022 оны 11 дүгээр сар 09-ний өдрийн Гүүрийн байгууламж, нүхэн гарцын байгууламжийн ашиглалт, үйлчилгээний ажил гүйцэтгүүлэх тухай А/227 тоот тушаалын хүрээнд Нийслэлийн хэмжээнд ашиглагдаж буй 4 гүүрэн гарцын 8 цахилгаан шатны хонгилд цахилгаан хүйтний улиралд ажиллуулах бэлтгэл ажлыг хангаж, лифтнүүдийн өдөр тутмын хэвийн ажиллагааг хариуцан ажиллаж байна.

ХУД-ын 1 дүгээр хорооны 120-н мянгатын гүүрэн гарцын лифтний тогны мөнгө төлөөгүйгээс лифт 2023 оны 03 дугаар сарын 20-30-ны хооронд зогссон.





## 4. Техникийн магадлал

Тайлант хугацаанд “Грийн хаус” СӨХ-ны 2 лифт, “Хур алтан өргөө” СӨХ 3 лифт, “Сүрлэг 21” СӨХ 2 лифт, “Сансар өргөө” СӨХ 2 лифт, “Ган зам 50, 50А” СӨХ-ны 4 лифт, “Баян өргөө” СӨХ-ны 1 лифт, “Оршил хотхон” СӨХ 5 лифт, “Өнөр 12” СӨХ-ны 5 лифт, “Өнөр 14” СӨХ-ны 1 лифт, “Клэстонбалансир” ХХК-ны 1 лифт, “Денвер 11” СӨХ-ны 4 лифт, “Орон гэр” СӨХ-ны 1 лифт, нийт 31 лифтэнд техникийн ээлжит магадлалын ажил хийж гүйцэтгэсэн.

БЗД-ийн 42-р хорооны нутаг дэвсгэр байрлах “Грийн хаус” СӨХ-ны 4 лифтийг шалгаж, гэмтлийн акт гаргаж өгсөн.



## 5. Лифтчин бэлтгэх сургалт



**Шинэ сургалт**

“ГОЛДЕН РИЧ ОДЦ” ХХК-тай хамтран 2023 оны 03 дугаар сарын 24-27-ны өдрүүдэд лифтчин бэлтгэх сургалтыг зохион байгуулж шинээр 7 лифтчин бэлтгэсэн.

## 6.Бусад ажил

### Албан бичиг

Нийслэлийн захиргааны нэгдсэн нутгийн байгууллагуудын систем <https://erp.ulaanbaatar.mn/> нэгдсэн сайтаар ИТХ-т нийт 27 алын бичиг ирсэн байна.

### Арга хэмжээ

2023 онд хэрэгжүүлэх ажлаа сурталчлах зорилгоор 2023 оны 03 дугаар сарын 18, 24-ны өдөр УБЗАА-наас зохион байгуулагдсан “Хот нийтийн аж ахуйн чиглэлийн байгууллагуудын нээлттэй хаалганы өдөр”-т оролцож, ажлаа сурталчилж ажилласан



### Бүх нийтийн цэвэрлэгээ

2023 оны 03 дугаар сарын 13-ны өдөр байгууллагын гадаах ойр орчмын 50м газрын их цэвэрлэгээг ажилд оролцсон.



**Анхаарал хандуулсан баярлалаа**